

## “ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ТӨГСГӨЛИЙН ШАТНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн түвшинг тогтоон үнэлгээ хийж, түүнд нөлөөлсөн хүчин зүйлүүдийн талаар дүгнэлт гарган цаашид хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, үр өгөжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

### ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2013 оны 322 тогтоолоор баталсан “Захирааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгэний нийтлэг журам”-ын дагуу 2010-2016 оны жилийн эцсийн тайлан судлах, тухайн асуудлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох газруудаас мэдээлэл авах, статистикийн мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийх замаар үнэлгээг гүйцэтгэв.

### ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр нь Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан 2 үе шаттайгаар хэрэгжиж дууссан.

I үе шат 2009-2012 он.

II үе шат 2013-2016 он

#### Хөтөлбөрийн зорилго:

Иргэн, төр, олон нийт, хувийн хэвшлийн зохистой оролцоог хангах замаар хүн амыг тэжээллэг, эрүүл ахуйн баталгаатай хүнсээр жигд, хүртээмжтэй, тогтвортой хангаж, эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, Монгол брэндийн органик хүнсийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөхүйц эдийн засгийн шинэ чадавхийг бүрдүүлэх

#### Хөтөлбөрийн зорилт:

Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 13 зорилтыг хэрэгжүүлнэ.

*Нэгдүгээр тэргүүлэх чиглэл. Хүнсний аюулгүй байдлыг хангах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын таатай орчин бүрдүүлэх.*

Зорилт 1. Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг ойрын болон хэтийн хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсронгуй болгох;

Зорилт 2. Эдийн засаг, санхүү, бизнесийн таатай орчин бүрдүүлж дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

Зорилт 3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, салбар дундын зохицуулалт болон боловсон хүчний чадавхийг сайжруулах.

*Хоёрдугаар тэргүүлэх чиглэл. Хүн амыг тэжээллэг, эрүүл ахуйн баталгаатай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах, хэрэглээн дэх үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний хувийн жинг нэмэгдүүлэх.*

Зорилт 4. Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах;

Зорилт 5. Хот, хөдөөгийн болон улирлаас хамаарах хүнсний хүртээмжийн ялгааг багасгах;

Зорилт 6. Байгалийн гамшиг, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнсний хомсдлын үед хүн ам, ялангуяа эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах;

Зорилт 7. Хүнсний үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж Монгол брэндийн хүнс экспортлох нөхцөлийг бүрдүүлэх.

*Гуравдугаар тэргүүлэх чиглэл. Хүнсний бүтээгдэхүүн, ундны усны эрүүл ахуйн баталгааг хангах хяналт, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох.*

Зорилт 8. Хүнсний түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх дамжлагад хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлуудыг нэвтрүүлж бүтээгдэхүүний эрүүл ахуйн баталгааг хангах;

Зорилт 9. Хүнсний аюулгүй байдлын хяналт, мэдээллийн сүлжээ, үйл ажиллагааг сайжруулах;

Зорилт 10. Ундны усны хүртээмж, чанар, эрүүл ахуйг сайжруулах.

*Дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл. Хүнсний тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хооллолтыг дэмжих, хоол, тэжээлийн дутлыг бууруулах, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэх.*

- Зорилт 11. Монгол хүний зохистой хоололтын зөвлөмжийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, хоол тэжээлийн талаархи хүн амын боловсролыг дээшлүүлэх;
- Зорилт 12. Хоол тэжээлтэй холбоотой өвчин, эмгэгээс сэргийлэх, хяналт тавих;
- Зорилт 13. Зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх.

Санхүүжилтийн эх үүсвэр:

- аж ахуйн нэгж, иргэдийн өөрийн хөрөнгө;
- улсын төсөв;
- орон нутгийн төсөв;
- банкны зээл;
- гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж; хөнгөлөлттэй зээл;
- дотоод, гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам  
Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЭМЯ, БСШУСЯ, БОАЖЯ, ХНХЯ, МХЕГ, ОБЕГ, СХЗГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоод, ТББ, үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэд;

#### ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТ, ҮР ДҮН

	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Арга хэмжээний биелэлт
1.	Зорилт 1. Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль, тогтоомжийг ойрын болон хэтийн хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсронгуй болгох;	<p><u>2009-2014 он:</u></p> <p>1.Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг ойрын болон хэтийн хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсронгуй болгох хүрээнд: ҮХААЯ-наас холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулга, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барьж батлуулсан.</p> <p>2.“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг УИХ-аас 2011 онд баталж, хуулийг хэрэгжүүлэх хүрээнд “Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 29 дүгээр тогтоол, “Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн бирж байгуулах, бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 235 дугаар тогтоол гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.</p> <p>3.Гамшиг тохиолдсон үед хүн амыг хүнсний зүйлээр хангах зорилгоор улсын нөөцийн хүнсний бараа, материалыг батлагдсан төсвийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 248 дугаар тогтоолоор баталсан байршил, нэр төрөл, тоо хэмжээгээр бүрдүүлж, технологийн дагуу хадгалж байна.</p> <p>4.2012 онд хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын нийт 6 стандартыг батлуулан, төлөвлөсөн бусад стандартуудыг техникийн хорооны хэлэлцүүлэгт оруулсан.</p> <p>5. Монгол Улсын Шадар сайдын 2012 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 42 дугаар тушаалаар Үндэсний стандартын шинжлэх ухаан техникийн түвшинд улсын үзлэгийг удирдан зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүнийг баталж, эхний хуралдааныг 2012 оны 12 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан. Хүнсний салбарын нийт 753 стандартад шинжлэх ухаан, техникийн түвшинд үзлэг хийж, техникийн хороогоор хэлэлцүүлсэн.</p> <p><u>2015 он:</u></p> <p>1.Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол/ 2. Засгийн газрын 2015 оны 492 дугаар тогтоолоор “Мах” хөтөлбөр 3. “Хүнсний аюулгүй сав” дэд хөтөлбөрийг ХХАА-н сайдын 2015 оны А/102 дугаар тушаалаар батлуулав.</p> <p><u>2016 он:</u></p> <p>1.Органик хүнсний тухай хууль батлуулав. 2.Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг батлуулав. 3.“Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалт”-ыг Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 64 дүгээр тушаалаар тус тус батлуулав.</p>

		<p>4. Хүнсний аюулгүй байдалтай холбогдох дараах хуулийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д 2016 оны 12 дугаар сарын 28-нд өргөн бариад байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Мал, амьтны эрүүл мэндийн тухай;</li> <li>- Малын генетик нөөцийн тухай;</li> </ul> <p>5. УИХ-ын нэр бүхий гишүүд Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, 2016 оны 12 дугаар сарын 28-нд УИХ-д өргөн барьсан. Тус хуулийн төслийн ажлын хэсэгт яамны зүгээс хамтран ажиллаж байна.</p> <p>6. Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төсөлд 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэсэн.</p> <p>7. Махны үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний шалгаруулалтыг зохион байгуулж, энэ арга хэмжээний дүнд боловсруулсан техникийн зохицуулалтын төслийг хүлээж авсан.</p> <p>8. Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хүрээнд дараах 15 эрх зүйн акт 2013-2016 онд батлагдсан, мөрдөгдөж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам;</li> <li>- Хүнсний туухий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам;</li> <li>- Өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлоход ачилтын өмнөх хяналт, шалгалт хийх журам;</li> <li>- Үндэсний лавлагаа лабораторийн ажиллах журам;</li> <li>- Эрсдлийн үнэлгээ хийх багийн ажиллах журам;</li> <li>- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, биобэлдмэлийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох акт;</li> <li>- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдлээс шалтгаалан зайлшгүй сав баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журам;</li> <li>- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтанд тавих, эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журам;</li> <li>- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох акт;</li> <li>- Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх аргачлал;</li> <li>- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам;</li> <li>- Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дүрэм;</li> <li>- Өргөн хэрэглээний хүнсний жагсаалт батлах тухай журам;</li> <li>- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх аргачлал, зөвлөмж.</li> </ul> <p style="text-align: right;"><i>ХШҮ-100%</i></p>
	<p>Зорилт 2. Эдийн засаг, санхүү, бизнесийн таатай орчин бүрдүүлж дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;</p>	<p><u>2009-2012 он:</u></p> <p>1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил болон тураг мах, шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор дайвар бүтээгдэхүүнийг нэмэгдсэн өртгийн албан татвараас, жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, хөдөө аж ахуйн зориулалттай трактор, комбайн, машин механизм, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж, УИХ-аар батлуулав.</p> <p>2. Нэмэгдсэн өртгийн албан татвар, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд Монгол Улсын Их Хурлын 2012 оны 1 дүгээр сарын 19-ний</p>

		<p>өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулснаар хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгааны тоног төхөөрөмж, хүлэмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг импортын албан татвар болон дотоодод худалдан борлуулсан. орлогын нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж, хуулийн үйлчлэх хугацааг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан болно. Дээрхи хуулиудад зааснаар гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх трактор, комбайн, машин механизм, бусад техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг Засгийн газрын 2012 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>3. Дотоодын үйлдвэрлэлийн зах зээлийг хамгаалах, түүнийг хөгжүүлэх эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх зорилгоор импортын гурил, хүнсний ногооны гаалийн албан татварын хувь хэмжээг улирлын ялгаваргүйгээр жилийн турш 15 хувь болгох тогтоолын төсөл боловсруулан УИХ-аар батлуулсан.</p> <p>4. Түүнчлэн 50 хүртэл сая төгрөгийн борлуулалтын орлого бүхий жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг 1 хувь хүртэл бууруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, дэмжсэн.</p> <p>5. ЖДҮХС-н эх үүсвэрээр 2012 онд мах махан бүтээгдэхүүн, гурил гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж нийт 11 төсөлд 6 тэрбум 408 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.</p> <p>6. 2012 онд малчин, хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэх 44740 иргэнийг хамруулан ХЭДС-аас 33.860,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд 2012 оны 5 сарын байдлаар өссөн дүнгээр ХАС, ХААН, Капитал, Хадгаламж банкуудаар дамжуулан 3339 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1720 малчин, 128 нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, 49 албан бус хөдөлмөр эрхлэгч, 65 ажилгүй иргэн, 17 аж ахуйн нэгж, байгууллагад 12 тэрбум 508.853 сая төгрөгийн зээлийг олгосноор 14042 хүн ажлын байраар хангагдсан байна.</p> <p><u>2013 он:</u></p> <p>1. Улсын төсвөөс “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 2009-2012 онд нийт 7189.1 сая төгрөг, 2013 онд 2 170.5 сая төгрөг зарцуулж бизнесийн орчин бүрдүүлсэн.</p> <table border="1" data-bbox="598 1254 1492 1579"> <thead> <tr> <th>Арга хэмжээ</th> <th>Төсөв, сая төгрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөхөд зээлийн дэмжлэг үзүүлэх</td> <td>1630.5</td> </tr> <tr> <td>Гахайн аж ахуй эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэх</td> <td>330.0</td> </tr> <tr> <td>Өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор тахианы аж ахуй эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэх</td> <td>160.0</td> </tr> <tr> <td>Зөгийний аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид зээлийн дэмжлэг</td> <td>50.0</td> </tr> <tr> <td>Дүн</td> <td>2170.5</td> </tr> </tbody> </table> <p>- Төсөл хэрэгжсэн бүс нутаг дахь 190 гаруй хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид нийт 291,000 еврогийн лабораторийн болон мал эмнэлгийн багаж хэрэгсэл олгосон.</p> <p>- Төрийн захиргааны болон сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газарт дор дурдсан тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлсэн байна.</p> <table border="1" data-bbox="598 1825 1492 2105"> <thead> <tr> <th>Хүлээн авагч</th> <th>Үнийн дүн</th> <th>Нэр төрөл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Биокомбинат ТӨААТҮГ</td> <td>52,000</td> <td>Хөргүүр, компьютер, авто машин</td> </tr> <tr> <td>ШУТИС-ХИБТС</td> <td>29,000</td> <td>Мах шинжлэгч</td> </tr> <tr> <td>Мэргэжлийн хяналтын ерөнхий</td> <td>31,000</td> <td>Мах шинжлэгч</td> </tr> <tr> <td>МАОЭШХ</td> <td>4,020</td> <td>Хөргүүр</td> </tr> <tr> <td>ХААИС</td> <td>91,000</td> <td>Лабораторийн багаж, компьютер</td> </tr> <tr> <td>Малын удмын сангийн үндэсний</td> <td>2,200</td> <td>Сүү шинжлэгч</td> </tr> <tr> <td>Булган аймгийн мал эмнэлэг.алба</td> <td>86,000</td> <td>Лаборатори, мал эмнэлгийн багаж,</td> </tr> </tbody> </table>	Арга хэмжээ	Төсөв, сая төгрөг	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөхөд зээлийн дэмжлэг үзүүлэх	1630.5	Гахайн аж ахуй эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэх	330.0	Өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор тахианы аж ахуй эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэх	160.0	Зөгийний аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид зээлийн дэмжлэг	50.0	Дүн	2170.5	Хүлээн авагч	Үнийн дүн	Нэр төрөл	Биокомбинат ТӨААТҮГ	52,000	Хөргүүр, компьютер, авто машин	ШУТИС-ХИБТС	29,000	Мах шинжлэгч	Мэргэжлийн хяналтын ерөнхий	31,000	Мах шинжлэгч	МАОЭШХ	4,020	Хөргүүр	ХААИС	91,000	Лабораторийн багаж, компьютер	Малын удмын сангийн үндэсний	2,200	Сүү шинжлэгч	Булган аймгийн мал эмнэлэг.алба	86,000	Лаборатори, мал эмнэлгийн багаж,
Арга хэмжээ	Төсөв, сая төгрөг																																					
Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөхөд зээлийн дэмжлэг үзүүлэх	1630.5																																					
Гахайн аж ахуй эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэх	330.0																																					
Өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор тахианы аж ахуй эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэх	160.0																																					
Зөгийний аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид зээлийн дэмжлэг	50.0																																					
Дүн	2170.5																																					
Хүлээн авагч	Үнийн дүн	Нэр төрөл																																				
Биокомбинат ТӨААТҮГ	52,000	Хөргүүр, компьютер, авто машин																																				
ШУТИС-ХИБТС	29,000	Мах шинжлэгч																																				
Мэргэжлийн хяналтын ерөнхий	31,000	Мах шинжлэгч																																				
МАОЭШХ	4,020	Хөргүүр																																				
ХААИС	91,000	Лабораторийн багаж, компьютер																																				
Малын удмын сангийн үндэсний	2,200	Сүү шинжлэгч																																				
Булган аймгийн мал эмнэлэг.алба	86,000	Лаборатори, мал эмнэлгийн багаж,																																				

	Дархан-Уул аймгийн мал	69,000	Лаборатори, мал эмнэлгийн багаж,
	Орхон аймгийн мал эмнэлгийн	62,500	Лаборатори, мал эмнэлгийн багаж,
	Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн	95,000	Лаборатори, мал эмнэлгийн багаж,
	Төв аймгийн мал эмнэлгийн алба	124,00	Лаборатори, мал эмнэлгийн багаж,
	Улаанбаатар хотын мал эмнэлгийн	58,000	Лаборатори, мал эмнэлгийн багаж,
	МЭЭШХ	13,800	Хөргүүр
	УМЭАЦТЛ	96,000	Лабораторийн багаж, компьютер, хөргүүр, хийн хроматограф, масс
	МЭЭСБУЛ	45,000	

2014 он:

1.Зээлийн батлан даалтын сангаас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 2014 онд 8 банктай хамтран ажиллаж, 2014 онд нийт 325 иргэн, аж ахуйн нэгжийн 52.0 тэрбум төгрөгийн зээлд 21.6 тэрбум төгрөгийн батлан даалтыг хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга, бөөний болон жижиглэн худалдаа, тээвэр, мэдээлэл холбоо, зочид буудал, нийтийн хоол, эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний бусад салбарт гаргасан.

2.“Нөөцийн махны менежер”-т урамшуулал олгох ажлын хүрээнд нөөцийн махны тонн тутамд 1000 төгрөг /2011 оноос/, Улаанбуудайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор буудай үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас дотоодын гурилын үйлдвэр, ТЭДС-д нийлүүлсэн буудайн тонн тутамд 2007 онд 60.0, 2008 онд 80.0, 2009 онд 50.0, 2010 онд 50.0, 2011 онд 50.0, 2012 онд 100.0, 2013 онд 100.0 /баруун бүсэд 150.0/, 2014 онд 70.0 /баруун бүсэд 105.0/ мянган төгрөг олгосон нь үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд түлхэц болсон байна.

3.ХАБ-ын Үндэсний Лавлагаа лабораториос 2014 онд лабораторийн итгэмжлэлийн хүрээг хувиргасан амьд организмыг илрүүлэн тодорхойлох 13 үзүүлэлт, хөрсний шинжилгээний 4, хүнсний бүтээгдэхүүнд бенз-а-перин 1 үзүүлэлт, GC-MS аргаар 14 пестицид, эм биобэлдмэл дэх GC аргаар үлдэгдэл уусгагч тодорхойлох 1, биологийн идэвхит нэгдэл тодорхойлох 4, ургамлын эрүүл ахуйн 7, нийт 42 үзүүлэлтээр өргөтгөсөн.

2015 он:

1.Хөдөө аж ахуйн “Халх гол” чөлөөт бүсийг байгуулсан ба Халх гол чөлөөт бүсийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хүлээж аваад байна.

2.Махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр БНХАУ руу 2016-2018 онд 6.0 тэрбум юанийн өртөг бүхий 150.0 мянган тн үхэр, хонины мах нийлүүлэх санаж бичгийг үзэглэсэн, махны үйлдвэрүүдэд импортлогч улсын холбогдох байгууллагуудтай хамтран хянан магадлагаа явуулж, БНХАУ руу мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхийг давхардсан тоогоор 11 үйлдвэр, БНСВУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхийг давхардсан тоогоор 8 үйлдвэрт тус тус олгосон.

3.ЖДҮХС-аас 18467.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 277 төсөлд олгосон нь хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал дэмжлэг болж, 57 үйлдвэр өргөтгөл хийж, 18 үйлдвэр байгуулагдсанаар 400 ажлын байр шинээр бий болж, 347 ажлын байрыг хадгалах нөхцөл бүрдсэн байна.

4.Орон нутгийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр ЖДҮДС, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сан болон бусад эх үүсвэрээс олгож байгаа зээлийн тодорхой хэсгийг жил бүр хуваарилж байгаа нь чухал дэмжлэг болоод байна.

5.2015 оны 11 сард “Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг Монгол Улс, БНХАУ-д экспортолж, импортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцлийн тухай” протоколд гарын үсэг зурсан. БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газрын Бүртгэл, гэрчилгээжүүлэлтийн газраас дулааны аргаар боловсруулсан үхэр, хонины мах, махан бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлох зөвшөөрлийг Мах маркет, Монгол эко мах ХХК, “Хүн-Од” ХХК, “Хатан сүйх” ХХК-д олгосон .

2016 он:

1.Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох хуулийг УИХ-аас 2016 оны 11 дүгээр сарын 24-ний

		<p>өдөр багалсан. Уг хэлэлцээрийн хүрээнд гаалийн үйлчилгээг шуурхай болгох, бараа бүтээгдэхүүн, дамжин өнгөрөх тээврийг чөлөөтэй нэвтрүүлэх, үл ялгаварлах зарчмыг баримтлах, худалдааны зардлыг бууруулах, техникийн туслалцаа үзүүлж чадавхийг бэхжүүлэх боломж, нөхцөл бүрдэнэ.</p> <p>2.Үр тарианы үйлдвэрлэлд 2016 онд нийт 33.2 тэрбум төгрөгийн, үүнээс буудайн урамшуулалд 16 тэрбум, шатахуунд 9.4 тэрбум, үрийн буудайнд 7.8 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Дарханы УГТХ-тэй 2016 онд гэрээ байгуулан захиалгаар улаан буудайн нутагшсан 4 шинэ сортын 344 тн элит үр, арвай, хөх тариа, хошуу будаа, вандуйны нутагшсан шинэ сортын 180 тн элит үрийг хүлээн авч үрийн нөөц бүрдүүлэв. Хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор 2016 онд “КР-2” төслийн санхүүжилтээр нийт 7.8 мянган тн эрдэс бордоог 378 аж ахуйн нэгжид 60 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгов. Мөн ТЭДС-гаас 288 аж ахуйн нэгжид нийт 233.3 тн ургамал хамгааллын бодисыг 30 хувийн урьдчилгаатайгаар олгосон.</p> <p>3.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2016 онд хүнсний үйлдвэрлэлийн салбарт 36 төсөлд нийт 12.67 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. Энэ дэмжлэгийн үр дүнд хүнсний чиглэлээр 82 үйлдвэр шинээр байгуулагдаж, 225 үйлдвэрт өргөтгөл хийгдсэн байна. Зээлийн батлан даалтын сангаас 2016 онд жижиг, дунд үйлдвэрийн төслүүдэд нийт 37.8 тэрбум төгрөгийн батлан даалтыг хийсэн байна.</p> <p>4.Дорнод аймгийн Халхгол суманд хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай УИХ-ын 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 46 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолын хүрээнд хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийг байгуулах, энэ бүсийн хэмжээ, хилийн зааг, мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагаа, тариалангийн технологи болон холбогдох журмыг тогтоох зэрэг ажлыг хэрэгжүүлж байна.</p> <p>5.Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас Дорнод аймгийн 7 сумын 10 байршилд хөрсний хээрийн судалгааг газар дээр нь гүйцэтгэн, холбогдох стандартын дагуу хөрсний бичиглэл хийж, хөрсний дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнд тус аймгийн Баянтүмэн суманд 3000 га, Булган суманд 1500 га, Матад суманд 15000 га, Халх гол суманд 30000 га, Чулуунхороот суманд 4000 га буюу нийт 53500 га атар газрыг тариалангийн газрын ангилалд шилжүүлэх боломжтойг, харин Дашбалбар сумын 8000 га, Хөлөнбуйр сумын 5300 га буюу нийт 13300 га атрыг тариалангийн газрын ангилалд шилжүүлэх боломжтойг тогтоосон.</p> <p>6.2016 оны 01 дүгээр сард “Үхэр, хонь, ямааны мах экспортлох үеийн мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагын тухай протокол”-ыг үзэглэсэн.</p> <p>2016 оны 01 сарын 18-ны өдөр “Үхэр, хонь, ямааны махны мал эмнэлгийн гэрчилгээ”-ний загварыг БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газарт явуулж баталгаажуулсан. БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газрын Гэрчилгээ, бүртгэлжүүлэлтийн газраас Завхан аймгийн “Завхан хүнс групп” ХХК, “Бумномин” ХХК, “Тэс шим” ХХК, “ЭДГС” ХХК, Хөвсгөл аймгийн “Хөвсгөл мах маркет” ХХК (Монгол эко мах ХХК), Увс аймгийн “Монтува” ХХК (Грийн грэйс лэнд)-ийн махны үйлдвэрүүдэд бэлтгэсэн үхэр, хонь, ямааны махыг экспортлох зөвшөөрлийг тус тус олгосон.</p> <p>7. Монгол Улсаас хүнс экспортлохыг бодлогоор дэмжих худалдааны орчныг бүрдүүлсэн байна. Тухайлбал,  -Монгол Улсад үйлдвэрлэсэн 7200 нэр, төрлийн бүтээгдэхүүнийг Европын зах зээлд тарифын хөнгөлөлттэй гаргах боломж бүрдүүлсэн Европын Холбооны “Хөнгөлөлтийн ерөнхий систем GSP+”-д 2014 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс үргэлжлэн хамрагдсан.  -Япон улстай 2015 онд “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” байгуулж, үндэсний үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүнийг тус улсад тарифын хөнгөлөлттэйгээр экспортлох нөхцөл, боломжийг бүрдүүлсэн.</p>
--	--	--

ХШҮ-90%

<p>Зорилт 3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, салбар дундын зохицуулалт болон боловсон хүчний чадавхийг сайжруулах;</p>	<p><u>2009-2012 он :</u> Хүнсний салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагааг салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулах чиглэлээр анхаарч ажиллаж байна. Тухайлбал, ҮХААЯ-ны хэрэгжүүлж буй “Махны чанар, аюулгүй байдлыг сайжруулах”, “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл”, “Эмзэг бүлгийн хүн амын хүнсний баталгаат байдлыг сайжруулах” төслүүдийн үйл ажиллагааг үндэсний хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлж байна.</p> <p><u>2013 он:</u> Засгийн газрын 2013 оны 03 дугаар сары 02-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай” журмыг баталсан. Ерөнхий сайдаар ахлуулах Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл нь салбар хоорондын уялдааг ханган ажиллаж байна.</p> <p><u>2014 он:</u> 1.БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар МХЕГ-ын “Нэгдсэн төв лабораторийн барилга барих, техникийн чадавхи бэхжүүлэх” төслийн хүрээнд “Үндэсний лавлагаа лаборатори”-ийг байгуулж, 2013 онд ашиглалтад оруулсан. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, итгэмжлэгдсэн төрийн болон орон нутгийн, хувийн өмчит лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй энэ лавлагаа лабораторийн ажиллах дүрэм, журам Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолоор батлагдан, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. 2.Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас аймгуудын лабораторийн лаборантуудыг оролцуулан “Клиник лабораторийн чанарын гадаад үнэлгээ, стандартчилалын тогтолцоо” болон “Нян судлалын шинжилгээний арга” сэдэвт сургалт, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори магадлан шинжлэгч эмч нарын 3 хоногийн сургалт, Украин Улсын Хөдөө аж ахуйн академитэй хамтарч “Тариалангийн талбайгаас хэрэглэгчдийн ширээ хүртэлх шинжилгээний хурдавчилсан арга” сэдэвт сургалт, ҮХААЯ, “Хүнсний зах, төвүүдийн эздийн холбоо” ТББ-тай хамтран лабораторийн ажиллагсдын ур чадварыг сайжруулах сургалт, “Таалийн лабораторийн шинжээч-улсын байцаагчийн мэргэшүүлэх сургалт”, “Лаборатори итгэмжлэлд тавигдах шаардлага, MNS ISO/IEC 17025:2007” сэдэвт 3 өдрийн сургалтыг 2 удаа, “MNS ISO/IEC 17025:2007 стандартын дагуу аудит явуулах арга зүй” сэдэвт 2 өдрийн сургалтыг 2 удаа явуулж, сорилтын лабораторийн 150 гаруй ажилтныг хамруулсан. Гадаадын хөрөнгө оруулалт: Европын Холбооны “Малын эрүүл мэнд , мал аж ахуйн зах зээл” төслөөс:</p> <p><u>2015 он:</u> 1.Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2015.11.03-ны өдрийн 09 дугаар зөвлөмжөөр “Хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын стратеги /2016-2021/-ийг баталсан. 2.“Газар хөдлөлтийн гамшгийн үеийн орон нутгийн хүн амын хүнсний нөөц тооцох аргачлал”, “Хүнсний хангамж аюулгүй байдал үндэсний хөтөлбөр-гамшгийн үеийн хүнсний аюулгүй байдал”, Органик хүнсний талаар ойлголт мэдлэг өгөх 12 удаагийн сургалт, ”Органик хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалтын шинжээчийг бэлтгэх“ танхимын болон үзүүлэх сургалт, “Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадал, кодексийн стандартыг нэвтрүүлэх нь”, “Сүүний үйлдвэрлэл ба зохистой дадал, Төрөөс сүүний салбарыг хөгжүүлэхэд баримтлах бодлого, хэрэгжилт”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” хуулийн зүйл заалтыг хэрэгжүүлэх талаар, “Эрүүл ахуйн зохистой дадал хялбаршуулан нэвтрүүлэх”, “Хоол үйлдвэрлэлийн салбарт эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх нь”, “Хоол үйлдвэрлэлийн салбарт хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, ЭАЗД мөрдүүлэх нь” сэдэвт сургалтуудыг зохион байгуулав.</p> <p><u>2016 он:</u> 1.Стандарт, хэмжил зүйн газраас Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн үйл ажиллагаа “MNS ISO/IEC 17025:2007” стандартын шаардлагад нийцсэн тул 2016 оны 5 дугаар сарын 27-нд 3 жилийн хугацаатай давтан итгэмжилсэн. 2.Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих</p>
--	---

	<p>ерөнхий шаардлага “MNS ISO/IEC 17025:2007” стандартын сургалтыг 2016 онд 7 удаа зохион байгуулж нийт 277 хүнийг хамруулсан.</p> <p>3.МХЕГ-ын төв болон орон нутгийн харьяа 40, аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын харьяа Мал эмнэлгийн 18, бусад аж ахуйн нэгжийн харьяа 13 лабораторийг хими, нян судлалын шинжилгээний ур чадварыг сорих сорилтод хамруулсан.</p> <p>4.Улсын хэмжээнд 2016 оны байдлаар хүнсний бүтээгдэхүүний сорилтын итгэмжлэгдсэн 66 лаборатори үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ХХААХҮЯ-ны харьяа мал эмнэлгийн лаборатори – 16;</li> <li>2. МХЕГ-ын харьяа лаборатори – 22;</li> <li>3. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээ.байгууллагын лаборатори – 5;</li> <li>4. Хүнсний үйлдвэрийн дотоод хяналтын лаборатори – 19;</li> <li>5. Хүнсний худалдааны төвийн дэргэдэх лаборатори – 4.</li> </ol> <p>5.Хөдөө аж ахуйн техникийн ашиглалтад үнэлгээ өгөх, засвар үйлчилгээний оновчтой тогтолцоог бүрдүүлэх судалгааны ажил хийх, газар тариаланд нэвтэрч буй шинэ техникийн бүтээл шатахуун зарцуулалтын үлгэрчилсэн нормыг боловсруулах, тариаланчдад эзэмшүүлэх ажлыг 2016 онд ХААИС болон мэргэжлийн төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан.</p> <p>6.Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран “Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд лабораторийн чанарын тогтолцоог сайжруулах болон био аюулгүй байдлыг сайжруулах асуудлаар лабораторийн чанарын менежментийн сургалтыг 2013 оны 9 дүгээр сард зохион байгуулж, 9 аймгийн 25 ажилтныг хамруулсан.</p> <p>7.Мал эмнэлгийн холбоо, МХЕГ хамтран Нийслэл, Дундговь, Дорноговь, Завхан аймгуудын малын эмч нарт “МЭ-ийн эм бэлдмэлийн хяналт” сэдвээр 1 удаа, аймгуудын малын эмч нарт “Мал эмнэлгийн эм болон шинээр гарч буй өвчний хяналт” сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулав. Мөн 7 аймаг, хилийн боомтын 35 шинжээчийг хамруулан 7-14 хоногийн дадлагажих сургалтыг зохион байгуулсан.</p> <p>8.Лабораторийн микробиологич нарт зориулан шинжилгээний хурдавчилсан арга, хувиргасан амьд организмыг илрүүлэн тодорхойлох, нян судлалын лабораторийн биоаюулгүй ажиллагааг мөрдөх сургалтыг 10 дугаар сарын 8-наас 9-ний өдрүүдэд зохион байгуулж, 36 шинжээч, мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>9.БНСУ-ын эрүүл ахуй, орчны судалгааны хүрээлэнгийн мэргэжилтнүүдийг урьж, НМХГ, Хүчит шонхор худалдааны төв, Мах маркет ХХК-ийн дотоод хяналт, сорилтын лабораторийг бэхжүүлэх, чадавхийг сайжруулах, туршлага солилцох ажил зохион байгуулсан.</p> <p>10.Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага “MNS ISO/IEC 17025:2007 стандартын сургалтыг 2015 онд 6 удаа зохион байгуулж, 203 хүнийг, 2016 онд 7 удаа зохион байгуулж 277 хүнийг тус тус хамруулсан байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-90%</p>
--	--



Зорилт 4. Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах;	<p><u>2009-2012 он:</u></p> <p>1. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 онд 345,3 тэрбум төгрөгт хүрсэн нь 2011 оныхтой харьцуулахад 1,1 дахин, 2009 онтой харьцуулахад 1,5 дахин нэмэгдсэн байна.</p> <p>Хүнсний боловсруулах үйлдвэрлэлээс сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, ундаа үйлдвэрлэл жил бүр өсч байгаагийн зэрэгцээ нөөшилсөн жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, ургамлын тос, кетчуп, маойнез зэрэг импорт орлох шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх боломжтой боллоо.</p> <p>Хүн амын хэрэгцээт мах, гурил, төмсний хэрэгцээг 100.0 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний 10.1, хүнсний ногооны 52.0, өндөгний 26.1 хувийг тус тус хангаж байгаа бөгөөд гурилын үйлдвэрлэлд хэрэгцээтэй буудайг дотоодын үйлдвэрлэлээс бүрэн нийлүүлэх боломжийг бүрдүүлээд байна.</p> <p>Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 16.4 мян.тн мах, махан бүтээгдэхүүн, 47.7 сая литр сүү, сүүн бүтээгдэхүүн, 114,8 мян.тн гурил/нийт хураан авсан ургацын 24,0 хувь нь, 25,4 мян.тн талх үйлдвэрлэж өмнөх онтой харьцуулахад сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 11,7 хувиар, гурил үйлдвэрлэл 9,02 хувиар нэмэгдсэн байна. Нийт үйлдвэрлэсэн махны 18.4%-ийг экспортлоод байна.</p> <p>Улсын хэмжээгээр нийт 379,7 мян.га талбайд тариалалт хийснээс 479,3 мян.тн үр тариа, 245,9 мян.т төмс, 98,9 мян.т хүнсний ногоо хурааж авсан. Өмнөх оныхоос хураасан үр тариа 7,5%, төмс 22% нэмэгдэж харин хүнсний ногоо 0,1%-иар буурсан байна. Үүнтэй уялдуулан импортолсон зарим гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотор төмс 1,8 дахин, гурил 1,35 дахин, хүнсний ногоо 1,46 дахин буурсан үзүүлэлттэй байна.</p>																																																																																								
	<p><u>2013 он:</u></p> <p>Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/12 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу жишсэн хүн амын 2016 оны хүнсний хангамжийг урьдчилан тооцож үзэхэд гол нэрийн 8 төрлийн хүнсний бүтээгдэхүүний 78 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа нь хүнсний хангамж харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна.</p>																																																																																								
<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="582 1198 790 1344">Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл</th> <th data-bbox="790 1198 941 1344">Жишсэн хүн амын жилийн хэрэгцээ, мян.тн</th> <th data-bbox="941 1198 1093 1344">Дотоодын үйлдвэрлэл мян.тн</th> <th data-bbox="1093 1198 1228 1344">Импорт, мян.тн</th> <th data-bbox="1228 1198 1364 1344">Экспорт, мян.тн</th> <th data-bbox="1364 1198 1503 1344">Нийт, хэрэглээ мян.тн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="582 1344 790 1400">Мах, махан бүтээгдэхүүн</td> <td data-bbox="790 1344 941 1400">179.4</td> <td data-bbox="941 1344 1093 1400">398.1</td> <td data-bbox="1093 1344 1228 1400">12.8</td> <td data-bbox="1228 1344 1364 1400">6.7</td> <td data-bbox="1364 1344 1503 1400">404.2</td> </tr> <tr> <td data-bbox="582 1400 790 1444">Сүү</td> <td data-bbox="790 1400 941 1444">134.7</td> <td data-bbox="941 1400 1093 1444">474.2</td> <td data-bbox="1093 1400 1228 1444">23.1</td> <td data-bbox="1228 1400 1364 1444">8.9</td> <td data-bbox="1364 1400 1503 1444">488.4</td> </tr> <tr> <td data-bbox="582 1444 790 1489">Сүүн бүтээгдэхүүн</td> <td data-bbox="790 1444 941 1489">179.4</td> <td data-bbox="941 1444 1093 1489">118.7</td> <td data-bbox="1093 1444 1228 1489">4.1</td> <td data-bbox="1228 1444 1364 1489">0.04</td> <td data-bbox="1364 1444 1503 1489">122.8</td> </tr> <tr> <td data-bbox="582 1489 790 1534">Гурил</td> <td data-bbox="790 1489 941 1534">89.7</td> <td data-bbox="941 1489 1093 1534">60.0</td> <td data-bbox="1093 1489 1228 1534">138.4</td> <td data-bbox="1228 1489 1364 1534">2.2</td> <td data-bbox="1364 1489 1503 1534">196.2</td> </tr> <tr> <td data-bbox="582 1534 790 1579">Гурилан бүтээгдэхүүн</td> <td data-bbox="790 1534 941 1579">197.3</td> <td data-bbox="941 1534 1093 1579">55.1</td> <td data-bbox="1093 1534 1228 1579">17.9</td> <td data-bbox="1228 1534 1364 1579">0.5</td> <td data-bbox="1364 1534 1503 1579">72.5</td> </tr> <tr> <td data-bbox="582 1579 790 1624">Төрөл бүрийн будаа</td> <td data-bbox="790 1579 941 1624">70</td> <td data-bbox="941 1579 1093 1624">0</td> <td data-bbox="1093 1579 1228 1624">24.2</td> <td data-bbox="1228 1579 1364 1624">0.5</td> <td data-bbox="1364 1579 1503 1624">23.7</td> </tr> <tr> <td data-bbox="582 1624 790 1668">Сахар, чихрийн зүйл</td> <td data-bbox="790 1624 941 1668">20.6</td> <td data-bbox="941 1624 1093 1668">0</td> <td data-bbox="1093 1624 1228 1668">89.2</td> <td data-bbox="1228 1624 1364 1668">0.3</td> <td data-bbox="1364 1624 1503 1668">88.9</td> </tr> <tr> <td data-bbox="582 1668 790 1713">Төмс</td> <td data-bbox="790 1668 941 1713">125.6</td> <td data-bbox="941 1668 1093 1713">163.8</td> <td data-bbox="1093 1668 1228 1713">42.3</td> <td data-bbox="1228 1668 1364 1713">0</td> <td data-bbox="1364 1668 1503 1713">206.1</td> </tr> <tr> <td data-bbox="582 1713 790 1758">Хүнсний ногоо</td> <td data-bbox="790 1713 941 1758">179.4</td> <td data-bbox="941 1713 1093 1758">72.3</td> <td data-bbox="1093 1713 1228 1758">80</td> <td data-bbox="1228 1713 1364 1758">0.8</td> <td data-bbox="1364 1713 1503 1758">151.5</td> </tr> <tr> <td data-bbox="582 1758 790 1803">Жимс, жимсгэнэ</td> <td data-bbox="790 1758 941 1803">161.4</td> <td data-bbox="941 1758 1093 1803">2.1</td> <td data-bbox="1093 1758 1228 1803">37.4</td> <td data-bbox="1228 1758 1364 1803">1.2</td> <td data-bbox="1364 1758 1503 1803">38.3</td> </tr> <tr> <td data-bbox="582 1803 790 1848">Буурцагт ургамал</td> <td data-bbox="790 1803 941 1848">80.8</td> <td data-bbox="941 1803 1093 1848">0</td> <td data-bbox="1093 1803 1228 1848">4.9</td> <td data-bbox="1228 1803 1364 1848">0</td> <td data-bbox="1364 1803 1503 1848">4.9</td> </tr> <tr> <td data-bbox="582 1848 790 1892">Өндөг</td> <td data-bbox="790 1848 941 1892">17</td> <td data-bbox="941 1848 1093 1892">4.6</td> <td data-bbox="1093 1848 1228 1892">3.1</td> <td data-bbox="1228 1848 1364 1892">0</td> <td data-bbox="1364 1848 1503 1892">7.7</td> </tr> <tr> <td data-bbox="582 1892 790 1937">Хүнсний тос</td> <td data-bbox="790 1892 941 1937">22.4</td> <td data-bbox="941 1892 1093 1937">1.6</td> <td data-bbox="1093 1892 1228 1937">19.7</td> <td data-bbox="1228 1892 1364 1937">0.4</td> <td data-bbox="1364 1892 1503 1937">20.9</td> </tr> </tbody> </table>						Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн хүн амын жилийн хэрэгцээ, мян.тн	Дотоодын үйлдвэрлэл мян.тн	Импорт, мян.тн	Экспорт, мян.тн	Нийт, хэрэглээ мян.тн	Мах, махан бүтээгдэхүүн	179.4	398.1	12.8	6.7	404.2	Сүү	134.7	474.2	23.1	8.9	488.4	Сүүн бүтээгдэхүүн	179.4	118.7	4.1	0.04	122.8	Гурил	89.7	60.0	138.4	2.2	196.2	Гурилан бүтээгдэхүүн	197.3	55.1	17.9	0.5	72.5	Төрөл бүрийн будаа	70	0	24.2	0.5	23.7	Сахар, чихрийн зүйл	20.6	0	89.2	0.3	88.9	Төмс	125.6	163.8	42.3	0	206.1	Хүнсний ногоо	179.4	72.3	80	0.8	151.5	Жимс, жимсгэнэ	161.4	2.1	37.4	1.2	38.3	Буурцагт ургамал	80.8	0	4.9	0	4.9	Өндөг	17	4.6	3.1	0	7.7	Хүнсний тос	22.4	1.6	19.7	0.4	20.9
Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн хүн амын жилийн хэрэгцээ, мян.тн	Дотоодын үйлдвэрлэл мян.тн	Импорт, мян.тн	Экспорт, мян.тн	Нийт, хэрэглээ мян.тн																																																																																				
Мах, махан бүтээгдэхүүн	179.4	398.1	12.8	6.7	404.2																																																																																				
Сүү	134.7	474.2	23.1	8.9	488.4																																																																																				
Сүүн бүтээгдэхүүн	179.4	118.7	4.1	0.04	122.8																																																																																				
		<p><u>2015 он:</u></p> <p>1.Нийслэлийн төвлөрсөн ус хангамжийн худаг, насосны болон дамжуулах станц, УТЦ-ээс 297 дээж, 315 сумын ундны усны 856 эх үүсвэр (худаг), 21 аймгийн 20 сумын малчид унд, ахуйдаа хрглэдэг 178 (37%) гүний худаг, энгийн уурхайн 217 (45%) гар худаг, 7 (1%) механикжсан уурхайн худаг, 23 сумын 42 (9%) гол мөрөн, 40 (8%) булаг шандаас авсан 451 дээж , Говийн 5 аймаг 63 сумын 144 дээжинд химийн хорт бодис тодорхойлох шинжилгээ хийлгэсэн. Нийт 2748 дээжинд хими, нян судлал, хүнд металлын шинжилгээ хийлгэж үнэлгээ дүгнэлт өгсөн. 5 аймгийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт халдваргүйжүүлэх төхөөрөмж, 3 аймагт үерийн далан суваг байгуулж, 10 аймгийн 88 сумын ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулсан байна. Мөн ус зөөлрүүлэх, цэвэршүүлэх төхөөрөмж 26 сумын ундны усны эх үүсвэрт тавьсан ба шинээр худаг гаргах, 3 сумын төвийг төвлөрсөн шугам сүлжээтэй болгох, шугам хоолой солих зэрэг нийт 14.6 тэр бум төгрөгний ажил хийсэн байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-90%</p>
Зорилт 11. Монгол хүний зохистой хооллолтын зөвлөмжийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, хоол тэжээлийн талаархи хүн амын боловсролыг дээшлүүлэх;		<p><u>2009-2012 он:</u></p> <p>1.“Хүн амын хоол тэжээлийн физиологийн норм”, “Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлэн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамжтай холбогдсон тооцоо судалгаа хийхэд ашиглаж байна. “Намрын ногоон өдрүүд-2012” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хүнсний аюулгүй байдлын талаар сурталчилгаа, сургалт хэлэлцүүлэг хийв.</p> <p>2. Улсын хэмжээнд бага насны хүүхдийн эмчилгээ, сувиллын хоолны чиглэлээр 100 гаруй сувилал, цагаан хоолны газар, сургалтын 31 танхим үйл ажиллагаа явуулж, тэдгээрт нийт 57 мянган хүн хамрагдсан байна.</p> <p><u>2013 он:</u></p> <p>Аймаг, орон нутгийн хэмжээнд хүн амын хоол тэжээл, зохистой хооллолтын чиглэлээр Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал, хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн алба, Мерси кор Олон улсын байгууллагуудтай хамтран “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл мэнд”, “Эрүүл хүнс-Жаргалтай амьдрал”, “Зөв зохистой хооллолт” зэрэг сэдвүүдээр 70 гаруй удаа сургалт зохион байгуулж, сургууль, цэцэрлэг, иргэн , аж ахуй нэгжийн давхардсан тоогоор 8200 гаруй төлөөлөл хамрагдсан.</p> <p><u>2014 он:</u></p> <p>1.Аймаг, орон нутгийн хэмжээнд хүн амын хоол тэжээл, зохистой хооллолтын чиглэлээр Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал, хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн алба, Мерси кор Олон улсын байгууллагуудтай хамтран “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл мэнд”, “Эрүүл хүнс- Жаргалтай амьдрал”, “Зөв зохистой хооллолт” зэрэг сэдвүүдээр 70 гаруй удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 8200 гаруй сургууль, цэцэрлэг, иргэн , аж ахуй нэгжийн төлөөлөл хамрагдсан.</p> <p>2.Архангай, Дархан-Уул, Дорноговь, Хөвсгөл аймагт зохистой хооллолтын сургалтыг нийт 14 удаа 1051 хүнийг хамруулан зохион байгуулсан байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас “Хамт олон бүх нийтээрээ жин хасах” 6 сарын аян, “Эрүүл зөв хоолыг эрхэмлэгч ресторан” 5 сарын аян зохион байгуулж, “Зохистой хооллолтын дэмжигч” байгууллага, хамт олон, засаг захиргааны нэгж, өрхийг шалгаруулсан байна.</p> <p><u>2015 он:</u></p> <p>1.“Идэвхтэй амьдралын хэв маяг” сургалтад 282 хүнийг хамруулсан байна. Мянганы сорилтын сангийн эрүүл мэндийн төслийн хүрээнд архи, тамхинаас сэргийлэх, хөдөлгөөн, зөв хооллолт, “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих” үндэсний стратегийн хүрээнд “Эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөн”, “Эрүүл хүнс, зохистой хооллолт” сэдэвт, “Эрүүл ажлын байр” сэдэвт сургалтуудыг зохион байгуулав.</p> <p>2. ЭМСЯ-аас санаачлан “Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр 2016-2025”-ийг боловсруулж Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>3.“Эх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих стратеги 2015-2020”-ийг боловсруулж Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 325 дугаар тушаалаар батлуулсан.</p>

		<p>4.2015 оны 3 дугаар сард ШӨХТГ-тай хамтран Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг “Эрүүл, зөв хооллолт” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн.</p> <p><u>2016 он:</u></p> <p>1.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс ерөнхий боловсролын сургуулийн эмч, тогооч, нярав нарын зохистой хооллолт, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг жилд 1-2 удаа тогтмол зохион байгуулж байна. Мөн цэцэрлэгийн хүүхдийн хоолны асуудлаар тогооч, няравын 7, 14 хоногийн сургалтуудыг жилд 2 удаа зохион байгуулж нийт 300 гаруй хүнийг хамруулсан.</p> <p>2.Зөв зохистой хооллолтыг дэмжих талаар жил бүрийн 3, 4, 8, 9, 11 дүгээр сард дараах арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж хэвшүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-3 дугаар сард “Давсны талаарх мэдлэгийг дээшлүүлэх” дэлхийн 7 хоног;</li> <li>- 4 дүгээр сард “Дэлхийн усны өдөр”;</li> <li>-8 дугаар сард “Хүүхдийг эхийн сүүгээр хооллолтыг дэмжих” дэлхийн 7 хоног;</li> <li>-9 дүгээр сард “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” дэлхийн өдөр болон “Оюутны эрүүл мэнд” сарын аян;</li> <li>11 дүгээр сард “Чихрийн шижин өвчинтэй тэмцэх” дэлхийн 7 хоног.</li> </ul> <p>Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагыг түшиглэн хүн амд зохистой хооллолтын талаар зөвлөгөө өгөх кабинетууд байгуулагдсан бөгөөд эрүүл мэндийн байгууллагын баталсан төлөвлөгөөний дагуу жил бүр байнгын сургалт зохион байгуулж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
	<p>Зорилт 12. Хоол тэжээлтэй холбоотой өвчин, эмгэгээс сэргийлэх, хяналт тавих;</p>	<p><u>2009-2012 он:</u></p> <p>1.“Хүн амын хоол тэжээлийн физиологийн норм”, “Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлэн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамжтай холбогдсон тооцоо судалгаа хийхэд ашиглаж байна. “Намрын ногоон өдрүүд-2012” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хүнсний аюулгүй байдлын талаар сурталчилгаа, сургалт хэлэлцүүлэг хийв.</p> <p>2.“Эрүүл хүүхэд” аяны нээлтийг 2012 оны 3 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, үзлэгт хамрагдвал зохих нийт 976941 хүүхдээс 816941 хүүхэд буюу 83.6 хувийг нь хамруулж, мэдээллийн санд нийт 796680 хүүхдийн 97.5 хувийг нь бүртгэсэн байна. “Эрүүл хүүхэд” аяны үр дүнд Монгол Улс 0-18 хүртэлх насны бүх хүүхдийн эрүүл мэндийн цахим мэдээллийн сантай болсон.</p> <p>3. Улсын хэмжээнд бага насны хүүхдийн эмчилгээ, сувиллын хоолны чиглэлээр 100 гаруй сувилал, цагаан хоолны газар, сургалтын 31 танхим үйл ажиллагаа явуулж, тэдгээрт нийт 57 мянган хүн хамрагдсан байна.</p> <p>4. Эрүүл мэндийн яам, Азийн хөгжлийн банкттай хамтран “Бага насны хүүхдийн дундах хоол тэжээлийн архаг дутлыг бууруулах JFPR9131” төслийг 2009-2013 онд 5 аймаг, нийслэлийн 2 дүүрэгт хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд хүүхдэд зориулсан тэжээллэг нэмэгдэл хоол, хүнс үйлдвэрлэх, хоол тэжээлийн дуталтай хүүхдийн сувилал ажиллуулах, хүүхдийн асрамжлагчид зөвлөгөө, мэдээлэл түгээх зэрэг зорилго бүхий 11 загвар төслийг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн оролцоотой амжилттай хэрэгжүүлсэн.</p> <p><u>2013 он:</u></p> <p>1.“Хөхөөр хооллолтыг дэмжин өнгөрүүлсэн 10 жил” үндэсний долоо хоног, “Эхийн сүүгээр хооллохыг дэмжих” дэлхийн 7 хоногийн өдрөөр хөхөөр хооллолтын талаар сургалт сурталчилгааны ажлуудыг хийснээр эхийн сүүгээр дагнан хооллолт 13,0 хувиар нэмэгдэж, хүүхдийн хоол тэжээлтэй холбоотой өвчлөлийн тохиолдлууд 2,7 хувиар буурсан үзүүлэлт гарсан байна.</p> <p>2.Хоол үйлдвэрлэлийн салбарт мөрдөгдөж байгаа стандартуудад үзлэг шалгалт явуулж, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх арга хэмжээ авч ажилласан. Дор дурдсан стандартуудыг батлан мөрдөж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Хоолны газрын нийтлэг журам: 2010 он;</li> <li>-Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага Монгол Улсын стандарт. Дугаар: MNS 4946:2005;</li> <li>-Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал: Монгол Улсын</li> </ul>

		<p>стандарт. Дугаар: MNS CAC RCP 39: 2009;          -Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг. Техникийн ерөнхий шаардлага: Монгол Улсын стандарт. Дугаар: MNS 6192 : 2010;          -Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал: Монгол Улсын стандарт. Дугаар: MNS CAC RCP 39- 2011;          -Гадна талбайд хоол хүнс бэлтгэх, борлуулах эрүүл ахуйн дадлын дүрэм: Монгол Улсын стандарт. Дугаар: MNS CAC RCP 43 - 2011.</p> <p><u>2014 он:</u>          1.“Хүүхэд бүрт аяга сүү” аяныг Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Ховд, Орхон, Хөвсгөл зэрэг аймгууд сайн зохион байгуулсан. 2013-2016 онд 6-59 сартай хүүхдэд олгох ОНБТ /олон найрлагат бичил тэжээл/-ийн захиалга, санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөөг болон ОНБТ-ийн зөвлөмж, хэмжээ, зааврыг тус тус боловсруулж батлуулсан.          2. “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоолоор батлуулсан, хэрэгжүүлж байна.</p> <p><u>2015 он:</u>          Хүнсний аюулгүй байдлыг хангуулах, халдвар хордлогоос урьдчилан сэргийлэх талаар МХЕГ-аас улсын хэмжээнд 6 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, телевизэд 214 удаа, өдөр тутмын хэвлэлд 49 удаа, байгууллагын сайтад 1621 удаа, радиод 86 удаа, 398 төрлийн зөвлөмж гарын авлага гарган мэдээлэл өгч ажилласаны дүнд хүнсний чиглэлээр бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн мэдлэгийн түвшинг нэмэгдүүлж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үндсэн нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллалаа. ХӨСҮТ-өөс хоол тэжээлтэй холбоотой өвчин, эмгэгээс сэргийлэх талаар цахим хуудсаар дамжуулан иргэдэд зөвлөмж, мэдээлэл бэлтгэн хүргэдэг.          2015 онд хоолны хордлогот халдварын 482 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн ам тутамд 1.6 тохиолдол ногдож байгаа нь нийт халдварт өвчний дотор 0.8 хувийг эзэлж байна. Өвчлөлийг өмнөх онд бүртгэгдсэн өвчлөлтэй харьцуулахад 66 тохиолдол буюу 10000 хүн ам тутамд 0.3-иор буурсан байна. Хоолны хордлогот халдварын нийт тохиолдлын 78 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.</p> <p><u>2016 он:</u>          1.Хүн амын хоол тэжээлийн үндэсний 5 дугаар судалгааг Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс хамтран улсын хэмжээнд 2016 онд хийсэн, тайланг боловсруулж байгаа бөгөөд 2017 оны 2 дугаар улиралд эцсийн байдлаар гарахаар хүлээгдэж байна.          2.Хоол хүнсний хангамж, татан авалтын судалгаанд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны төлөөлөл болсон нийт 1500 байгууллагыг хамруулсан. Тэдгээрийн дийлэнх нь долоо хоногт 2-3 удаагийн давтамжтайгаар сүү сүүн бүтээгдэхүүний 40-50 хувийг компани, 20-25 хувийг хувь хүн, мах махан бүтээгдэхүүний 19-23 хувийг компани, 15-25 хувийг хүн хүн, 13-29 хувийг малчин, гурил, будааны 52-63 хувийг компани, 4-13 хувийг хүнсний зах, 7-13 хувийг хоршоолол, төмс хүнсний ногооны 27-43 хувийг компани, 9-26 хувийг хүнсний зах зэрэг газруудаас гэрээний дагуу татан авч байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-90%</p>
Зорилт 13. Зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх		<p><u>2009-2012 он:</u>          1. Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр “Бага насны хүүхдийн хоол тэжээлийн архаг дутлыг бууруулах” IРРК 9131 төслийн хүрээнд “ГУМ” ХХК “Д” амин дэмээр баяжуулсан сүү үйлдвэрлэж байна.          2. НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр ХБНГУ-ын Мюленхем компаниас гурил баяжуулах 1000 кг примексийг импортлон гааль, нэмүү өртгийн албан татвараас чөлөөлүүлж гурилын үйлдвэрүүдэд олгож байна.</p> <p><u>2013 он:</u>          Иоджуулсан давс, баяжуулсан гурилын хэрэглээг сурталчлах 10 хоногийн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, энэ үеэр хийгдсэн 10 удаагийн сургалтад нийт 4451 хүнийг хамруулж, 837 ширхэг сурталчилгааны материалыг түгээсэн.</p> <p><u>2014 он:</u>          1.“Хүнсний тухай” хуулийн 8.1.4-т “хүний бие махбодийг бүхэлд нь, эсхүл</p>

	<p>тодорхой эрхтэний үйл ажиллагааг дэмжих шаардлагатай бодис, илчлэгийг нөхөх үйлчилгээ бүхий биологийн идэвхт бодис, баяжуулсан, ашигтай бичил биетэн агуулсан зохицуулах үйлчилгээтэй хүнсний үйлдвэрлэлд” төрөөс дэмжлэг, урамшуулал үзүүлэх тухай заалт тусгагдсан.</p> <p>2.“Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ҮХААЯ-ны ТНБД-ын 2014 оны А/170 дугаар тушаалаар байгуулсан.</p> <p>3.ҮХААЯ-наас зохион байгуулсан ”Буудайн гурил үйлдвэрлэх, баяжуулах технологи, хяналт” сэдэвт сургалтанд орон нутгийн 3 үйлдвэрийн 7 мастер, лаборант, мэргэжилтэнг хамруулж, үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах эрхийн үнэмлэх олгосон</p> <p>4.Нийслэлийн захирагчийн ажлын албанаас “Хавдраас сэргийлэх үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүн” хүний бие махбодь болон тодорхой нэг эрхтэний үйл ажиллагааг дэмжих биологийн идэвхт бодис, ашигтай бичил биетэн агуулсан зохицуулах үйлчилгээтэй хүнсний нийт 11 төрлийн зөвлөмж хүргүүлэв.</p> <p>5. Сүүний сургалтын үндэсний төв “Пропион хүчлийн бактериар баяжуулсан зөөлөн бяслаг үйлдвэрлэх”, “Бифидобактерийн цэвэр өсгөврийн хөрөнгө ашиглан аарц үйлдвэрлэх” инновацийн төсөл хэрэгжүүлж, жижиг үйлдвэрийн нөхцөлд нэвтрүүлсэн.</p> <p><u>2015 он:</u></p> <p>Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулгын 16.2-т заасны дагуу “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгэх” журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/110 дугаар тушаалаар батлуулан, ажлын хэсгийн уулзалтыг 4 удаа хийж, журмын төслийг боловсруулан, мэргэжлийн хяналтын байцаагчид, хүнс үйлдвэрлэгчдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар төслийг хэлэлцүүлж зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусган дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p><u>2016 он:</u></p> <p>1.УИХ-ын нэр бүхий гишүүдээс санаачлан боловсруулж УИХ-д 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр өргөн барьсан, хэлэлцүүлж байгаа Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллаж байна. Хуулийн төсөл батлагдсанаар баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, үр дүнг хянах, мэдээлэх эрх зүйн орчин бүрдэнэ.</p> <p>2.“Хатан сүйх импекс” ХХК-аас малын гаралтай хаягдал (гахайн өөх, бод, богийн зузаан цагаан хальс, бүлх шөрмөс г.м) болох коллагент түүхий эдийг ашиглан хиам баяжуулагч бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлээд байна. “Траст трейд” ХХК-аас ХБНГУ-ын технологийн дагуу 100% цэвэр гахайн махаар нитрит ороогүй, хүний биед ямарч сөрөг нөлөөгүй “Жаргалан” брэндийг гаргав.</p> <p>3.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс “Насанд хүрсэн монгол хүний сийвэн дэх селений дундаж хэмжээ” шинжлэх ухааны төсөлт судалгааг гүйцэтгэсэн. Судалгаанд үндэслэн “Түмэн шувуут” ХХК нь “Өндгийг селениэр баяжуулах”-ны төслийг амжилттай хэрэгжүүлж, дэлхийн 50 гаруй оронд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг АНУ-ын “Alltech” компанийг сонгон шалгаруулж, ахианы тэжээлд нэмэх селенийн бэлдмэлийг тус компаниас импортлон, үйлдвэрлэлдээ ашиглаж байна. “АПУ” ХХК “Сайн сүү” брэндийн бүтээгдэхүүнийг гаргаж Д аминдэмээр баяжуулан байгууллагын стандартаар батлуулан, зах зээлд борлуулж байна</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p>
--	--

ТАВ. “ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСГӨЛИЙН ҮЕ ШАТНЫ ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРСЭН ТҮВШИН

№	Үр дүн, хүрэх түвшин	Гүйцэтгэл	Биел элт %
<b>Нэгдүгээр тэргүүлэх чиглэл.</b>			
1	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, ариун цэврийн хяналт олон улсын нийтлэг жишигт хүрсэн байна.	“Хүнсний тухай” болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн хүрээнд 18 дүрэм, журам, аргачлал, зөвлөмж батлагдсан, 11 нь боловсруулалтын болон хэлэлцүүлэх шатанд байна.	70.0
2	Хүнсний аюулгүй байдлын үнэлгээг олон улсад хэрэглэдэг нийтлэг арга, үндэсний стандартад нийцүүлэн хийж, үр дүнг нийтэд мэдээлдэг болсон байна.	Үндэсний статистикийн хорооноос 2015 оны А/12 дугаар тушаалаар “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт”-ийг шинэчлэн баталсан. “Хүнсний аюулгүй байдлын статистик” 2014, 2015 танилцуулгыг гаргаж, нийтийн хүртээл болгосон. Хүнсний аюулгүй байдлын хууль, эрх зүйн орчныг нөхцөл байдал, хяналтын тогтолцоонд олон улсын экспертүүдтэй хамтарсан үнэлгээ 2016 онд хийгдсэн. Үнэлгээний тайланг ҮАБЗ-ийн Ажлын албанд эцэслэн боловсруулж байна.	90.0
<b>Хоёрдугаар тэргүүлэх чиглэл.</b>			
3	Хот орчмын сүүний чиглэлийн фермерийн аж ахуйнуудаас жилд 40.0 мянган тонн сүү нийлүүлнэ. Үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээг 2012 оноос 2 дахин нэмэгдүүлнэ	Сүүний чиглэлийн фермерийн аж ахуйнуудаас 2016 онд 69.7 мян тн сүүг нийлүүлсэн.	100.0
		Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 73 сая л хүрсэн.	100.0
4	Махны экспортыг 38.0 мянган тоннд хүргэж, хот суурингийн хүн амын хэрэгцээт махны 60-аас доошгүй хувийг үйлдвэрийн аргаар боловсруулдаг болсон байна.	Махны экспорт 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 8.2 мян тн мах экспортолсон.	30.0
		Улаанбаатар, Эрдэнэт, Дарханы /жишсэн/ хүн амын махны хаврын улирлын хэрэгцээ 23.3 мян тн. Үйлдвэрийн аргаар 2016 оны урьдчилсан дүнгээр нийт 15.3 мян тн махыг бэлтгэсэн байна.	70.0
5	Хүнсний ногоо, өндөгний хэрэгцээг бүрэн, цөцгийн тосны 20, загасны 25, жимсний 15, будааны 5, ургамлын тосны 40-өөс доошгүй хувийг дотооддоо үйлдвэрлэдэг болсон байна.	Хүнсний ногооны хангамжийн 47.7 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан.	50.0
		Өндөгний хангамжийн 59.5 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан.	59.5*
		Цөцгийн тос болон загасны хэрэгцээг тооцох боломжгүй.	- -
		Жимсний хангамжийн 5.5 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан.	36.6*
		Будаа тариалах туршилт хийгдсэн.	-
	Хүнсний тосны хангамжийн 7.7 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан.	19.25*	
6	Гамшгийн үеийн нөөцийн гурилыг 20 хоногийн, цагаан будаа, элсэнчирхийг 15 хоногийн хэрэгцээтэй тэнцэх, стратегийн нөөцийн улаан буудайг нийт хэрэгцээний 50 хувьд хүргэсэн байна.	Стратегийн нөөцийн хүнсний бараа, материал 80 гаруй хувийн, гамшгийн нөөцийн хүнсний бараа, материал 70 гаруй хувийн биелэлттэй байна.	Улсын нууцын зэрэглэлтэй тул дүгнэх боломжгүй.
7	Газар тариаланд хэрэглэх бордооны 30 хувийг, ургамал хамгааллын бодисын 20 хувийг дотооддоо үйлдвэрлэж, газар тариалангийн чиргүүл, дүүжин машины 50 хувь, өөрөө явагч техникийн 70 хувийг шинэчилсэн байна	Жилд ойролцоогоор 140 мянган тн бордоо шаардлагатай бөгөөд 2015 онд бордооны 2 үйлдвэр шинээр байгуулагдаж, 23760 тонн бордоо үйлдвэрлэснээр бордооны хангамж 20 хувьд хүрсэн.	66.7
		Газар тариалангийн чиргүүл, дүүжин машины 50 хувийг шинэчилсэн.	100.0

		Өөрөө явагч техникийн 67 хувийг шинэчилсэн байна.	95.7
		Ургамал хамгааллын бодис дотооддоо үйлдвэрлэдэггүй.	-
8	Бүх сумын 60-70 хувь нь бөөний худалдааны сүлжээ, салбартай болсон байна.	Бөөний худалдааны төвийг 18 аймагт байгуулж 116 сумыг буюу 35.2 хувийг хамруулсан.	58.58
9	Хот суурингийн орчимд хөдөө аж ахуйн болон боловсруулах үйлдвэрийн 25-аас доошгүй цогцолбор бий болно.	“Гацуурт” махны үхэр – махны үйлдвэр, “Ажигана” ХХК-ийн “Оргио” тахианы аж ахуй – үйлдвэр, “Мон таримал” ХХК-ийн сүүний ферм – сүү боловсруулах үйлдвэр, “Хишигтэн нүүдэлчин” ферм – сүү боловсруулах үйлдвэр, “Арвин хур” ХХК-ийн газар тариалан – ургамлын тос, гурвалжин будаа, шарсан төмсний үйлдвэр, “НБЦ” ХХК-ийн өндөглөгч тахиа – өндөгний үйлдвэр, “Тайширын хүлэг” ХХК-ийн сүүний ферм – сүүний үйлдвэр, мөн орон нутагт 11 гурилын үйлдвэр-газар тариалангийн цогцолбор бий болсон.	90.0
1	Тариаланд шаардагдах нийт үрийн 60-80 хувийг I-III зэргийн үрээр тариалдаг болж, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 54.0 мянган га-д хүргэж, нийт ургацын 15-аас доошгүй хувийг усалгаатай талбайгаас авдаг болно.	Тариаланд шаардагдах нийт үрийн 80 хувийг I-III зэргийн үрээр тариалдаг болсон.	100.0
		Усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 54.1 мянган га-д хүрсэн.	100.0
		Нийт ургацын 35 хувийг усалгаатай талбайгаас авч байна.	100.0
<b>Гуравдугаар тэргүүлэх чиглэл.</b>			
11	Хүнсний үйлдвэрүүдэд дотоод хяналтын тогтолцоо бүрэн нэвтэрч, чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг зах зээлээс буцаан татах журам бий болж мөрдөгдөнө.	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн журмыг Засгийн газрын 2014 оны 157 дугаар тогтоолоор, Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журмыг Засгийн газрын 2013 оны 172 дугаар тогтоолоор тус тус батлуулсан, мөрдүүлж байна.	100.0
12	Хүнсний үйлдвэрүүдийн 60 хувьд аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) нэвтэрсэн байна.	Хүнсний үйлдвэрлэлд аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР)-г “Дархан meat фүүдс” ХХК-ийн мал төхөөрөх, сэврээх, хэсэглэх, ангилах, савлах, хөлдөөх, хадгалах үйл ажиллагаанд, “Мах маркет” ХХК-ийн мах шулж, ангилах савлах үйл ажиллагаанд, “Ажигана” ХХК-ийн тахиа төхөөрөх үйл ажиллагаанд тус тус нэвтрүүлсэн.	30.0
		Хөдөө аж ахуйн, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал, хүнсний үйлдвэрлэлд аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо нэвтрүүлэх аргачлал, зөвлөмжийг МХЕГ-ын даргын 2014 оны 79 дүгээр тушаалаар баталсан.	90.0
13	Хөдөө аж ахуйн фермерүүдийн 55-аас доошгүй хувьд нь хөдөө аж ахуйн зохистой дадал (GAP) нэвтэрсэн байна.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014 оны 156 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Газар тариалангийн үйлдвэрлэлд ХАА-н зохистой дадлыг нэвтрүүлэх зөвлөмж”-ийг, 2 дугаар хавсралтаар “Мал эмнэлэгт ХАА-н зохистой дадлыг нэвтрүүлэх зөвлөмж”-ийг тус тус баталсан. Сургалт зохион байгуулсан.	20.0



14	Хоол хүнсээр дамжих өвчлөл буурсан байна	2015 онд хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт 6 удаа бүртгэгдэж 311 хүн өвчилсний 33 буюу 10.6 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, хүний амь нас эрсдээгүй байна. 2014 онтой харьцуулахад хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт 1.8 дахин, өвчилсөн хүний тоо 2.4 дахин буурсан. /2016 оны дүн гараагүй байна/	100.0
<b>Дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл.</b>			
15	Тав хүртэл насны хүүхдийн дундах тураал 3.8 хувь, өсөлт хоцролт 9.8 хувь, туранхай 0.2 хувь, Д аминдэмийн дутал 25 хувь, А аминдэмийн дутал 6 хувь, цус багадалт 10.7 хувь, 7-12 насны хүүхдийн бахлуур өвчний тархалт 3 хувь, хөхүүл эхчүүдийн дундах А аминдэмийн дутал 11.5 хувь, жирэмсэн эмэгтэйчүүдийн цус багадалт 10 хувь хүртэл буурч, Монгол Улсын Мянганы Хөгжлийн зорилт хангагдсан байна.	5 хүртэлх насны хүүхдийн өсөлт, хоцролт 10.8 хувь /2015/ тураалтай 1.6 хувь /2015/ туранхай 1.0 хувь	90.0
		Д аминдэмийн дутал 21.8 хувь /2010/ А аминдэмийн дутал 32.4 хувь /2010/ цус багадалт 26.5 хувь /2010/	V судалгааны үр дүн гарахаар хүлээгдэж байна.
		7-12 насны хүүхдийн бахлуур өвчний тархалт 7.4% /Хүн амын хоол тэжээлийн үндэсний IV судалгаа 2010/	
		Хөхүүл эхчүүдийн дундах А аминдэмийн дутал	
		Жирэмсэн эмэгтэйчүүдийн цус багадалт 26.5%	
		16	Хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэж байгаа хүн амын хувь 2012 оныхоос 50 хувь буурсан байна.
17	Хүн амд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үндэсний тогтолцоог бүрдүүлсэн байна.	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үндэсний тогтолцоо бүрдсэн. Улсын хэмжээнд тооцсон амьжиргааны баталгаажих түвшний 5 хувийн шугамаас доогуурт багтсан хүн амын хамгийн бага хэрэглээтэй хэсэгт хүнсний эрхийн бичиг /талон/ олгох ажлыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар 2013 оноос хэрэгжүүлсэн. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 2013-2015 онд нийт 320.9 мянган иргэн хамрагдсан.	100.0
<b>Дундаж үнэлгээ</b>			<b>74.7</b>

\*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас 2016 оны хүнсний тэнцлийг урьдчилан тооцсон дүн

#### ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт (ололт, дутагдал, асуудлууд)	Хөтөлбөрийн 2016 оны зорилт, үйл ажиллагааны ерөнхий хэрэгжилт <b>85.4</b> хувьтай байна. Хөтөлбөрт дэвшүүлсэн 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 17 үр дүнд хүрэхээр шалгуур үзүүлэлтийг төлөвлөсөн. 2016 оны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг дүгнэхэд дунджаар <b>74.7</b> хувьтай байна. <b>Ололт:</b> - Монгол Улсын хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн 2016 оны индексийг 2010 оныхтой харьцуулахад 139.5%, үүнээс мах, загас, жимс, ногоо, өөх тос боловсруулалт 119.6%, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 158.2%, үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл 134.1%, хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл 144.1% буюу төрөл тус бүрээр 19,6-58,2 хувиар өссөн дүнтэй байна. - “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу тооцоход гол нэрийн 8 төрлийн хүнсний бүтээгдэхүүний <b>78</b> хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа нь хүнсний хангамж харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна. - Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулга - Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай
--------------------------------------	---

	<p>- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай</p> <p>- Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга</p> <p>- Органик хүнсний тухай хуулиуд батлуулав.</p> <p>- Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого зэрэг УИХ-ын болон Засгийн газрын холбогдох тогтоолуудыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>- Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хүрээнд дараах 15 эрх зүйн акт 2013-2016 онд батлагдсан, мөрдөгдөж байна</p> <p>- Дотоодын үйлдвэрлэлийн зах зээлийг хамгаалах, түүнийг хөгжүүлэх эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх зорилгоор импортын гурил, хүнсний ногооны гаалийн албан татварын хувь хэмжээг улирлын ялгаваргүйгээр жилийн турш 15 хувь болгов.</p> <p>- Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил болон тураг мах, шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор дайвар бүтээгдэхүүнийг нэмэгдсэн өртгийн албан татвараас, жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, хөдөө аж ахуйн зориулалттай трактор, комбайн, машин механизм, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөв.</p> <p>- Нэмэгдсэн өртгийн албан татвар, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд Монгол Улсын Их Хурлын 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулснаар хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгааны тоног төхөөрөмж, хүлэмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг импортын албан татвар болон дотоодод худалдан борлуулсан. орлогын нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж, хуулийн үйлчлэх хугацааг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан болно.</p> <p>- БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар МХЕГ-ын “Үндэсний лавлагаа лаборатори”-ийг байгуулж, ашиглалтад оруулснаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, итгэмжлэгдсэн төрийн болон орон нутгийн, хувийн өмчит лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулан ажиллаж байна.</p> <p>- “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу жишсэн хүн амын 2016 оны хүнсний хангамжийг урьдчилан тооцож үзэхэд гол нэрийн 8 төрлийн хүнсний бүтээгдэхүүний 78 хувийг дотоодын үйлдвэрлэж байгаа нь хүнсний хангамж харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна.</p> <p><b><u>Дугагдал:</u></b></p> <p>-2016 онд 38,0 мянган тонн мах экспортлох зорилттой байсан хэдий ч 8,2 мянган тонн (зорилтот түвшний 22%) мах гадаадад гаргасан байна. Хүн амын хэрэгцээнд зориулан мах нөөцлөх ажиллагаа ба махны экспортийн хэмжээ урвуу хамааралтай байна. Статистикийн үзүүлэлтээс дүгнэвэл 2004-2008 онд 3-7 мянган тонн мах дотоодын нөөц бэлтгэж байх үед жилд дунджаар 11,6 тонн мах экспортолж байсан байна. Гэтэл 2011-2012 онд 12.0, 2013-2015 онд 14.0 мянган тонн мах нөөцлөхөд дунджаар 3.6 мянган тонн мах экспортолсон нь даруй 3.2 дахин буурсан үзүүлэлттэй байна. Махны үйлдвэрлэл эрхлэгч нар олон улс хэм хэмжээ, эрүүл ахуйн өндөр шаардлага бүхий мах экспортлохоос илүүтэйгээр дотооддоо нөөц бэлтгэж, малчдын бэлгэсэн махыг хүлээн авч, хадгалж борлуулалтанд шилжүүлэх нь өртөг зардлын хувьд хямд, үйл ажиллагааны хувьд амар хялбар байж болох тайлтай.</p> <p>-Хүнсний ногоо, өндөгний хэрэгцээг бүрэн, цэцгийн тосны 20, загасны 25, жимсний 15, будааны 5, ургамлын тосны 40-өөс доошгүй хувийг дотооддоо үйлдвэрлэдэг болсон байх зорилттой ажилласан боловч 2016 оны байдлаар хүнсний ногооны 47,7%, өндөгний 59,5%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Жимсний 5,5%, ургамлын тосны 7,7%-ийг үндэсний үйлдвэрлэлээр хангаж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.</p> <p>- Хүнсний үйлдвэрүүдийн 60 хувьд аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) нэвтэрсэн байхаар заасан, мал нядлах,</p>
--	---

		<p>мах боловсруулах 2, тахиа төхөөрөх 1 аж ахуйн нэгж аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР)-ыг нэвтрүүлээд байгаа нь анхаарвал зохих асуудал юм.</p> <p><b>Зөвлөмж:</b></p> <p>-Дотоодын мах боловсруулах үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр хөнгөлттэй зээл олгож, нөөцийн мах бэлтгэл болон мах экспортийг жигд нэмэгдүүлэх шаардлагатай. Хүнсний тухай хуулинд заасны дагуу нөөцийн мах бэлтгэлийг орон нутагт хариуцуулах, ХХААХҮЯ-ны оролцоог багасгах.</p> <p>-Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр удаашралтай, хангалтгүй биелэлттэй гарсан хүнсний ногоо, өндөг, цөцгийн тос, загас, жимс, ургамлын тосны үйлдвэрлэлтэй холбоотой зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг бүрэн хангахад анхаарч ажиллах.</p> <p>-Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй, дотоодод үйлдвэрлэсэн ч нэгж бүтээгдэхүүний өртөг гарах цагаан будаа, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүнийг заавал эх орондоо тариалах ургуулах, боловсруулахыг зорилгүй, импортоос хангаж байхаар тогтож, бодлого, шийдвэрт тусгах.</p> <p>-Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд 2012 онд батлагдснаас хойш үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) болон аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР)-ыг нэвтрүүлэх талаар яам, хяналтын байгууллага, олон улсын төслийн хүрээнд олон тооны сургалт явуулсан боловч нэвтрүүлсэн үйлдвэр, аж ахуйн нэгжийн тоо цөөхөн байх тул сургалтын үр дүн муутай, хяналт сул, үр дүнг тооцох аргачлал байхгүй тул салбарын хэмжээнд сургалтын талаар мөрдөх журам гаргах, мөрдүүлэх, сургалтын үр дүнг тооцох кредитийн нэгдсэн систем бий болгох.</p> <p>- Аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) нэвтрүүлсэн хүнсний үйлдвэрүүдийн дэмжих, алдаршуулах, бусдад туршлага дамжуулах талаар яамнаас санаачлага гаргах, үл нэвтрүүлсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийг хуулийн заалт дагаж мөрдүүлэх талаар арга хэмжээ авах.</p>																																
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ холбогдох яамд, төрийн байгууллага, дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд, олон улсын байгууллагууд, хэвлэл, мэдээллийн байгууллагууд, аймгуудын ХХААГ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх илүү санаачлагатай ажиллах нь зүйтэй дүгнэж байна.																																
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	<table border="1"> <tr> <td>Зорилт</td> <td>1</td> <td>2</td> <td>3</td> <td>4</td> <td>5</td> <td>6</td> <td>7</td> </tr> <tr> <td>Биелэлт</td> <td>100 %</td> <td>90%</td> <td>90%</td> <td>70%</td> <td>70%</td> <td>90%</td> <td>90%</td> </tr> <tr> <td>Зорилт</td> <td>8</td> <td>9</td> <td>10</td> <td>11</td> <td>12</td> <td>13</td> <td>Дундаж</td> </tr> <tr> <td>Биелэлт</td> <td>70%</td> <td>90%</td> <td>90%</td> <td>100%</td> <td>90%</td> <td>70%</td> <td><b>85,4%</b></td> </tr> </table>	Зорилт	1	2	3	4	5	6	7	Биелэлт	100 %	90%	90%	70%	70%	90%	90%	Зорилт	8	9	10	11	12	13	Дундаж	Биелэлт	70%	90%	90%	100%	90%	70%	<b>85,4%</b>
Зорилт	1	2	3	4	5	6	7																											
Биелэлт	100 %	90%	90%	70%	70%	90%	90%																											
Зорилт	8	9	10	11	12	13	Дундаж																											
Биелэлт	70%	90%	90%	100%	90%	70%	<b>85,4%</b>																											
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	<p style="text-align: center;">Нэгдсэн үнэлгээ</p> <p style="text-align: center;">... %</p>																																

**“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН  
II ҮЕ ШАТНЫ САНХҮҮЖИЛТ**

№		2013	2014	2015	2016	
1	Улсын төсөв /сая төг/	Хүнсний үйлдвэрийн салбар /Сайдын багц/	117.1	414.0	357.0	118.5
2		ШУТ-ийн сан	-	200.0	115.2	-
3		Буудайн урамшуулал	12988.6	25295.5	24727.1	5591.5
4		Махны урамшуулал	11399.5	9500.0		14500.0
5		ЖДҮХС-гаас хүнсний үйлдвэрлэлд олгосон зээл	10960.0	19310.0	13530.0	12670.0
6		Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн зээл	8200.0	47300.0	5500.0	-
7	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө /мян дол/	“Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх” төсөл /НҮБ-ын ХХААБ/	-	268.0		
8		“Кодексийн үндэсний чадавхийг бэхжүүлэх нь” төсөл /НҮБ-ын ХХААБ/		294.0		-
9		“Органик хөдөө аж ахуйг дэмжих” төсөл /НҮБ-ын ХХААБ/	-	352.0		
10		“Өмнөд-өмнөдийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн /II шатны/ хүрээнд БНХАУ-тай хамтран Монгол Улсын “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийг дэмжих техник туслалцаа”		999.29		
11		“Монгол улс дахь хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил” төсөл /I шат/		1283.0*		
12		“Монгол төмс” хөтөлбөр		3000.0		
13		Хөдөө аж ахуйн маркетинг		12500.0*		
14	Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр/сая төг/	136000.0	126000.0	55000.0	-	

- Улсын төсвийн хөрөнгө 222.14 тэрбум төгрөг  
үүнээс:
  - Буудайн урамшуулал 68.6
  - Махны урамшуулал 35.4
  - Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зээл 56.5
  - Чингис бондын санхүүжилтээр олгосон зээл 61.0
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө 18.69 сая доллар
- “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний  
үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр 317 тэрбум төгрөг